

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/229-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2023 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан	19-21
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23-24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА М.НЯМСҮРЭН ТАНАА

2023.02.14 № СЭА-2023/229-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 96.3 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлс, нэмэгдэл урамшлыг 3.9 хувиар, НДШ-ийг 3.0 хувиар, тогтмол зардлыг 2.6 хувиар тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, батлагдсан төсвийг 3.7 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 87.7 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос

төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 47,814.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 50,768.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Амжилт
 Төрийн сангийн харилцах
 Төгрөг
 /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,191,377.00	13,702,169.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0	40,000.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0	40,000.00
31210	Төгрөг	0	40,000.00
31211	Төрийн сангийн харилцах	0	40,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,191,377.00	13,662,169.00
35400	Хангамжийн материал	10,191,377.00	13,662,169.00
35410	Бичиг хэргийн материал	0	979,575.00
35420	Аж ахуйн материал	9,131,677.00	9,960,077.00
35440	Түлш, шатах тослох материал	1,059,700.00	2,722,517.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,203,870,112.08	1,158,882,828.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,203,870,112.08	1,158,882,828.51
39200	Биет хөрөнгө	1,160,642,045.40	1,115,752,781.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,049,878,122.01	1,049,878,122.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	-91,975,555.59	-125,334,653.07
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,000,000.00	89,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-27,138,888.93	-41,638,888.87
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	148,838,864.31	203,556,622.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-53,685,260.79	-101,121,493.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	73,671,658.60	87,067,658.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,081,656.07	-54,128,594.55
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,227,164.70	11,227,164.70
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,552,262.84	-3,403,017.12
39217	Ном	459,860.00	649,860.00
39300	Биет бус хөрөнгө	43,228,066.68	43,130,047.14
39301	Программ хангамж	1,245,411.80	1,245,411.80
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,135,745.12	-1,233,764.66
39303	Бусад биет бус хөрөнгө	43,118,400.00	43,118,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,214,061,489.08	1,172,584,997.51
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,214,061,489.08	1,172,584,997.51
51	Засгийн газрын хувь оролцоо	1,214,061,489.08	1,172,584,997.51
51100	Засгийн газрын оруулсан капитал	363,793,993.87	0
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	363,793,993.87	0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0	363,793,993.87
51200	Хуримтлагдсан үр дүн	257,904,458.51	216,427,966.94
51210	Өмнөх үеийн үр дүн	102,005,143.18	257,904,458.51
51220	Тайлант үеийн үр дүн	155,899,315.33	-41,476,491.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	592,363,036.70	592,363,036.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,214,061,489.08	1,172,584,997.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,361,731,747.00	1,424,725,728.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	252,482,747.00	56,615,628.36
120	Нийтлэг татварын бус орлого	252,482,747.00	56,615,628.36
120009	Бусад орлого	32,203,407.00	MIQA0065 90554360
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	215,795,020.00	54,303,758.36
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,484,320.00	2,311,870.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,109,249,000.00	1,368,110,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,109,249,000.00	1,357,310,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,109,249,000.00	1,357,310,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	10,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	9,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	1,800,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,201,460,505.39	1,466,202,219.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,201,460,505.39	1,466,202,219.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,172,541,284.67	1,406,652,931.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	823,220,692.00	1,017,841,514.40
210101	Үндсэн цалин	637,198,576.00	708,737,118.00
210102	Нэмэгдэл	133,082,875.00	247,762,654.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,950,000.00	23,871,000.00
210104	Урамшуулал	26,989,241.00	37,470,742.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,665,821.28	128,374,036.74
210201	Тэтгэврийн даатгал	75,110,719.14	87,900,896.65
210202	Тэтгэмжийн даатгал	8,318,533.24	10,341,281.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,580,906.72	8,185,665.59
210204	Ажилгүйдлийн даатгал	1,605,060.08	1,995,108.33
210205	Эрүүл мэндийн даатгал	16,050,602.10	19,951,084.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,822,752.00	46,854,930.07
210301	Гэрэл, цахилгаан	54,053,300.00	35,153,768.07
210302	Түлш, халаалт	0	3,010,000.00
210303	Цэвэр, бохир ус	8,769,452.00	8,691,162.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60,449,605.00	50,885,818.00
210401	Бичиг хэрэг	11,918,000.00	14,549,025.00
210402	Тээвэр, шатахуун	9,692,460.00	11,484,683.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,182,200.00	15,560,740.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,600.00	93,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,563,345.00	9,197,770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,756,000.00	33,499,047.00
210604	Урсгал засвар	17,756,000.00	33,499,047.00
2107	Томилолт, зочны зардал	3,660,000.00	5,673,900.00
210702	Дотоод албан томилолт	3,660,000.00	5,673,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,557,014.00	10,232,643.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,366,703.00	8,495,012.00

210803	Даатгалын үйлчилгээ	747,500.00	1,294,175.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,564.00	111,144.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	247,500.00
210807	Газрын төлбөр	39,747.00	40,812.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,409,400.39	113,291,041.93
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	92,409,400.39	113,291,041.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,919,220.72	59,549,288.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	7,960,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	7,960,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,919,220.72	51,589,288.79
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,919,220.72	51,589,288.79
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	160,271,241.61	-41,476,491.57
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,371,926.28	0
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	4,371,926.28	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	155,899,315.33	-41,476,491.57


2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан



Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,109,249,000.00	1,374,110,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	6,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0	6,000,000.00
120009	Бусад орлого	0	6,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,109,249,000.00	1,368,110,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,109,249,000.00	1,357,310,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,109,249,000.00	1,357,310,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	10,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	9,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	1,800,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,091,749,000.00	1,360,070,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,091,749,000.00	1,360,070,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,062,829,779.28	1,300,520,811.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	823,220,692.00	1,017,841,514.40
210101	Үндсэн цалин	637,198,576.00	708,737,118.00
210102	Нэмэгдэл	133,082,875.00	247,762,654.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,950,000.00	23,871,000.00
210104	Урамшуулал	26,989,241.00	37,470,742.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,665,821.28	128,374,036.74
210201	Тэтгэврийн даатгал	75,110,719.14	87,900,896.65
210202	Тэтгэмжийн даатгал	8,318,533.24	10,341,281.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,580,906.72	8,185,665.59
210204	Ажилгүйдлийн даатгал	1,605,060.08	1,995,108.33
210205	Эрүүл мэндийн даатгал	16,050,602.10	19,951,084.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,822,752.00	47,814,930.07
210301	Гэрэл, цахилгаан	54,053,300.00	35,153,768.07
210302	Түлш, халаалт	0	3,970,000.00
210303	Цэвэр, бохир ус	8,769,452.00	8,691,162.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,403,500.00	50,768,740.00
210401	Бичиг хэрэг	11,918,000.00	15,528,600.00
210402	Тээвэр, шатахуун	8,209,700.00	12,187,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,182,200.00	15,560,740.00
210404	Ном, хэвлэл	0	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,600.00	93,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000,000.00	6,398,300.00
2105	Нормативт зардал	1,200,000.00	316,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	316,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,300,000.00	33,499,047.00
210604	Урсгал засвар	22,300,000.00	33,499,047.00
2107	Томилолт, зочны зардал	3,660,000.00	5,673,900.00
210702	Дотоод албан томилолт	3,660,000.00	5,673,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,557,014.00	10,232,643.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,366,703.00	8,495,012.00

210803	Даатгалын үйлчилгээ	747,500.00	1,294,175.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,564.00	111,144.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	247,500.00
210807	Газрын төлбөр	39,747.00	40,812.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	6,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	6,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,919,220.72	59,549,288.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	7,960,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	7,960,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,919,220.72	51,589,288.79
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,919,220.72	51,589,288.79
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	17,500,000.00	14,040,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	17,500,000.00	14,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,500,000.00	14,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,500,000.00	14,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,500,000.00	14,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-17,500,000.00	-14,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	40,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	40,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан



Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	102,005,143.18	1,058,162,173.75
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	102,005,143.18	1,058,162,173.75
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	155,899,315.33	155,899,315.33
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	257,904,458.51	1,214,061,489.08
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	257,904,458.51	1,214,061,489.08
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	257,904,458.51	1,214,061,489.08
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-41,476,491.57	-41,476,491.57
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	216,427,966.94	1,172,584,997.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан



Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,357,310,100.00	1,307,520,811.21	49,789,288.79	96.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,357,310,100.00	1,307,520,811.21	49,789,288.79	96.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,355,310,100.00	1,305,520,811.21	49,789,288.79	96.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,058,816,900.00	1,017,841,514.40	40,975,385.60	96.13
210101	Үндсэн цалин	715,192,900.00	708,737,118.00	6,455,782.00	99.10
210102	Нэмэгдэл	289,321,000.00	247,762,654.40	41,558,345.60	85.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,080,000.00	23,871,000.00	4,209,000.00	85.01
210104	Урамшуулал	26,223,000.00	37,470,742.00	-11,247,742.00	142.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,352,000.00	128,374,036.74	3,977,963.26	96.99
210201	Тэтгэврийн даатгал	89,999,400.00	87,900,896.65	2,098,503.35	97.67
210202	Тэтгэмжийн даатгал	10,588,200.00	10,341,281.85	246,918.15	97.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,470,500.00	8,185,665.59	284,834.41	96.64
210204	Ажилгүйдлийн даатгал	2,117,600.00	1,995,108.33	122,491.67	94.22
210205	Эрүүл мэндийн даатгал	21,176,300.00	19,951,084.32	1,225,215.68	94.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,100,000.00	47,814,930.07	1,285,069.93	97.38
210301	Гэрэл, цахилгаан	39,100,000.00	35,153,768.07	3,946,231.93	89.91
210302	Түлш, халаалт	4,000,000.00	3,970,000.00	30,000.00	99.25
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	8,691,162.00	-2,691,162.00	144.85
2104	Хангамж, бараа материалын зардал	50,773,700.00	50,768,740.00	4,960.00	99.99
210401	Бичиг хэрэг	17,918,000.00	15,528,600.00	2,389,400.00	86.66
210402	Тээвэр, шатахуун	12,187,500.00	12,187,500.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,568,200.00	15,560,740.00	-1,992,540.00	114.69
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	93,600.00	606,400.00	13.37
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,400,000.00	6,398,300.00	-998,300.00	118.49
2105	Нормативт зардал	800,000.00	316,000.00	484,000.00	39.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	316,000.00	484,000.00	39.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,500,000.00	38,499,047.00	953.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	33,500,000.00	33,499,047.00	953.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	5,682,400.00	5,673,900.00	8,500.00	99.85
210702	Дотоод албан томилолт	5,682,400.00	5,673,900.00	8,500.00	99.85
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,285,100.00	10,232,643.00	3,052,457.00	77.02

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан



Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		10,800,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,800,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,800,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		1,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		9,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		9,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		9,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		10,800,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		10,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,800,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газар /цаашид Шүүхийн Тамгын газар гэх/ нь “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, шүүхийн үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй хүргэх” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах, шүүхийн хүний нөөц, шүүхийн судалгаа, мэдээлэл, олон нийтийг мэдээллээр хангах зэрэг хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Шүүхийг өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах,
- Шүүхийн хөдөлмөр зохион байгуулалт, дотоод журмын биелэлтэд хяналт тавих,
- Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх,
- Шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах,
- Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах,
- Хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх.


3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Шүүхийн тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 12 дугаар сарын 23-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон,

- Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 193 дугаар тогтоолоор шүүгчийн туслах болон шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.



Шүүхийн Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ШЕЗ-ийн Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албанаас хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд дотоод хяналт шалгалт, аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ШЕЗ-ийн даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 174 дүгээр тушаалаар ШЕЗ-ийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41,476.5 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	40.0	40.0
Авлага	-	-	-
Бараа материал	10,191.4	13,662.2	3,470.8
Үндсэн хөрөнгө	1,203,870.1	1,158,882.8	(44,987.3)
Нийт хөрөнгө	1,214,061.5	1,172,585.0	(41,476.5)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,214,061.5	1,172,585.0	(41,476.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,214,061.5	1,172,585.0	(41,476.5)

Бараа материалын дансны үлдэгдэл 13,662.2 мянган төгрөг болж 3,470.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 62,649.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон ШЕЗ-өөс 2,311.9 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, 61,490.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,485,743.2 мянган төгрөг болж, 68,303.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 14,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан болон 54,303.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг ШЕЗ-өөс шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,172,585.0 мянган төгрөг болж 41,476.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг /улсын төсвөөс/ 2,326,489.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 385,870.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 497,063.6 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 100,000.0 мянган төгрөгөөр зэрэг нийт 1,095,907.4 мянган төгрөгөөр бууруулж, 1,230,581.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төслийг 1,095,907.4 мянган төгрөгөөр илүү төлөвлөсөн нь Тамгын хэлтсийн албан хаагчийн орон тоог 5, шүүгчийн орон тоог 4, нийт орон тоог 9-өөр нэмэгдүүлж төлөвлөн цалин хөлс, нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 345,576.9 мянган төгрөг, хурлын танхимын болон ерөнхий шүүгчийн өрөөний тавилга, эд хогшил худалдан авах зардлыг 177,000.0 мянган төгрөг, шүүх хуралдааны заал, архив, сургалтын өрөө, конторын барилгын засвар, үүдний өргөтгөл, сургалтын танхим барих зэрэгт урсгал засварын зардлыг 299,163.6 мянган төгрөг, суудлын автомашин худалдан авах зардалд 100,000.0 мянган төгрөгийг тооцоолж, төсөвт тусгаснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 126,728.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон /цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 118,874.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 9,288.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 6,626.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн бол, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 14,000.0 мянган төгрөгөөр бууруулж, баталсан нь голлон нөлөөлсөн/ байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,357,310.1 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,357,310.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,307,520.8 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 48,044.9 мянган төгрөгөөр, зөвлөл, хороо, комиссын гишүүдийн зардлыг 1,683.6 мянган төгрөгөөр, шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардлыг 60.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэнэс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,351,810.1	1,303,765.2	48,044.9	96.4
2	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	2,500.0	816.4	1,683.6	32.7
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	2,000.0	2,000.0	-	100.0
4	Шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардал	1,000.0	939.2	60.8	93.9
	Дүн	1,357,310.1	1,307,520.8	49,789.3	96.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.


3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130005401 тоот дансанд ШЕЗ-өөс 9,000.0 мянган төгрөг, Н.Цэрэнбатын төлбөр 1,800.0 мянган төгрөг зэрэг

нийт 10,800.0 мянган төгрөг шилжиж ирснийг шинээр томилогдсон 2 шүүгчийн тавилга, эд хогшилд 9,000.0 мянган төгрөгийг зарцуулж, 1,800.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.



4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.


Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,201,460.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,014.6 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ШЕЗ-ийн даргын 2022 оны 109 дүгээр “Төрийн хэмнэлтийн арга хэмжээний тухай” албан бичгээр ирүүлсэн ШЕЗ-ийн харьяа байгууллагуудад хэрэгжүүлэх хэмнэлтийн арга хэмжээний 5 зөвлөмжийг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга батыг мөрдөн, ил тод байдлыг ханган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шүүхийн Тамгын газрын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримттай холбоотой 15,395.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	15,395.0	2	15,395.0	100
Нийт дүн	2	15,395.0	2	15,395.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,161.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5,566.4 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1,595.3 мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

1. Архивын ажилтныг “Хөлсөөр ажиллах гэрээ”-ний хүрээнд ажиллуулж бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 4,984.3 мянган төгрөгийн цалин хөлс олгож, 582.1 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын “2108: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж: Хамаарахгүй зүйлс: Хувь хүнд ажил үйлчилгээ авсны төлөөсөнд олгож байгаа НДШ тооцогдох цалин хөлс, урамшуулал” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн албан хаагчийн урамшуулал давхардуулан олгосонтой холбоотой асуудал:

Илрүүлэлт: Нягтлан бодогч Л.Одонтуяагийн ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгосон боловч ШЕЗ-ийн даргын 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 187 дугаар тушаалаар 2021 оны ажлыг “Хангалттай” үнэлүүлсэн гэх үндэслэлээр 2 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,595.3 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг үр дүн, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, нэг ажлын үр дүнгээр урамшууллыг давхардуулан олгохгүй байх.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.




6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй				
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт	Албан шаардлага		Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
	Тоо	Дүн		Тоо	Дүн		Тоо	Дүн	
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	5,566.4							
Үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон.	1	1,595.3			1	1,595.3			
Дүн	2	7,161.7			1	1,595.3			



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						

